


溶接の安全衛生

Зурагт номоор ойлгох

Гагнуурын аюулгүй байдал, эрүүл ахуй



Энэхүү дүрс бичлэгийн материалыг гагнуурын ажил гүйцэтгэдэг ажлын байранд ажилладаг хүмүүст аюулгүй байдал, эрүүл ахуйн үндсийг сурч боловсруулахад зориулан бүтээсэн болно.



Өнөөдөр гагнуурын ажлын аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар сурцгаая!




Халуун объекттой харьцаж, хүнд эд ангиудыг ажиллуулах болохоор аюулгүй байдалдаа анхаарахгүй бол.

Тийм шүү



Ямар ажил хийдэг юм бол.


Юунаас болгоомжлох хэрэгтэй вэ?



Эхлээд хөдөлмөрийн осол гарч байгаа нөхцөл байдлыг авч үзье!

Тэгье

Гагнуурын ажилд гарсан хөдөлмөрийн ослын гол тохиолдлууд иймэрхүү байна.



Гагнуурын ажилд гарсан үйлдвэрлэлийн осол

- Хавчуулагдах орооцолдох
- Халуун объекттой харьцах
- Өндрөөс ойчих - Унах
- Өндрөөс нисэх-Юмнаас унах
- Гагнуурын цахилгаан хангамжийн цахилгаан цочрол
- Гагнасан утаанаас үүдэлтэй уушиг хордох
- Нуман гэрлийн улмаас нүд гэмтэх гэх мэт.



Гагнуурын ажилд янз бүрийн хөдөлмөрийн осол гардаг байх нь ээ.



Түүнчлэн аюултай газарт байрлуулсан гишгүүр, шатнаас унаж, ясаа хугалах,



барилгын талбайд гишгүүрээ хий гишгэж унах зэрэг ослын тохиолдол гардаг.


Аюул ойрхон байдаг байх нь ээ.



Тийм л учраас дүрмээ дагаж мөрдөх нь чухал юм.



Биеэ хамгаалахын тулд хамгаалалтын хэрэгслийг зааврын дагуу бэлтгэж,



зүй ёсоор нь өмссөний дараа ажлаа хийх.

Үүнээс гадна халуун зүйлтэй харьцахдаа болгоомжтой байх хэрэгтэй.




Яг зөв. Нуман гагнуур хийхдээ ялангуяа болгоомжтой байх хэрэгтэй.

Оч үсэрч магадгүй тул түлэгдэх тохиодол ч гарна. Түүнчлэн гал авалцах, дэлбэрэх эрсдэлтэй.



Ойлголоо.

За тэгвэл,




Бодит байдал дээр

харцгаая




Тохиолдол 1

Хамгаалалтын хэрэгсэл хэрэглэгээ





Халуун байна,
халуун байна
хөлс урсаад.




Одоо жаахан

Толгой эргээд
эхлэх чинь




Ашгүй!
Болчихлоо!




Яа аа
хал... халуун
байна.

Ус, ус, ус!




Үхэх нь л
гэж бодлоо



За, цэвэрлэе.



Гэгнүүрын саваа
гаргаад тэр чигээр нь
орхичихсон
байна.




Унтраагаа ч
үгүй байна.



Ёо




Аааааа




Эмхтгэл: Тохиолдол 1

1 Зориулалтын ажлын хувцас, хамгаалалтын хэрэгслийг өмсцгөөе!



2 Цахилгаанд цохиулахаас болгоомжил!



- Ажил эхлэхээс өмнө аюулгүй байдлын төхөөрөмжийг шалгах
- Цахилгаан цочролын эрсдэл, яаралтай тусламжийн хариу арга хэмжээг шалгах
- Хөлс таны хувцасыг норгож, цахилгаанд цохиулж болзошгүй тул анхааралтай байх
- Гагнуурын кабелийг зөв холбох


TIPS Гагнуурын утааг амьсгалахаас болгоомжил!





* Металлын халууралт (металлын утааны халууралт) гэдэг нь металл утаагаар амьсгалсанаас болж толгой өвдөх, халуурах, даарах, булчин өвдөх, дотор муухайрах, цангах, ядрах зэрэг шинж тэмдгүүд илэрдэг.

Тохиолдол 2

Унах, өндрөөс унахаас болгоомжил





Эд ангиудыг гагнасны дараа гагнасан хэсгийг хөрөх хүртэл орхино.

Энэ хооронд гагнах дараагийн эд ангийг авч ирнэ.




За, дараагийн эд ангийг авчрахаар явцгаая.

Уучлаарай, гэнэт гэдэс өвдчихлөө.



Ариун цэврийн өрөө явчихаад ирье. Хурдхан ирэх болохоор хүр хүлээгээрэй.



10 минутын дараа

Удаж байна шүү. Яаралтай ажил байхад.



Материал хадгалах газар

Ганцаараа зөөж чадаж магадгүй.

Үүнийг өргөж үзье.



Ёо оо

Хөөх, ямар хүнд юм бэ

Энэ болохгүй юм байна.



Хөөе
яасан бэ?



Материалыг
хөл дээрээ
унагачихлаа.

Шууд
эмнэлэг
явъя.



Эдгэртэл 2 сар гаруйн хугацаа зарцуулах хугарал байна. Аюулгүйн гутал өмссөн бол хүнд гэмтэл авахгүй байлаа.

Дүрмийг дагаж мөрдөх нь үндсэн зүйл гэдгийг би сайн ойлголоо.




Чамайг гэмтчихээр найз нөхөд, гэр бүлийнхэн чинь санаа зовох болно.

Тэр дүрмийг дагаж мөрдөхөө өөртөө хатуу тангараглав.


ЭМХТГЭЛ: Тохiolдoл 2

1 Эд ангиудыг хөдөлгөхдөө тогтсон дарааллаар хийх




2-уулаа хамтарч том хэсгүүдийг зөөж, ажлын тавцан дээр байрлуулах.

Тэгээд гагнуурыг эхлүүлэх.



Ганцаараа чадахгүй ажлыг хийхгүй байх.

2 Ажлын үеэр аюулгүйн гутал өмсөх.



Аюулгүйн гуталны хоншоор хэсэг нь хатуу тул хөлийн хуруунуудыг хамгаалдаг.

TIPS

Дотуур хувцас хөвөн даавуу байх!
Гагнуур хийх үед амархан шатах синтетик материалаар хийгдсэн цамц өмсөж болохгүй!



Өнөөдөр синтетик материалаар хийгдсэн дотуур хувцас өмсөж үзсэн.

Гэхдээ халуун байгаа тул хүрэмний товчийг тайлчихъя.



Үсрэх хайлсан металлын хэсэг



Яана аа Үсэрсэн хэсэг цээж үрүү орчихлоо.

- Гагнуурын хэсэг үрүү хэт ойртож болохгүй.
- Ажлын хувцсыг дүрмийн дагуу өмсөх.
- Синтетик материалаар хийсэн цамц нь шатамхай.

Тохиолдол 3 Нүдээ анхаарах





Өнөөдөр халуун байна шүү, хөлс гараад зогсохгүй нь ээ.




Нүд үрүү орчихлоо. Хамгаалалтын шил хазайчихсан юм байх даа.



Нулимс гараад зогсохгүй байна.

Яана аа, улайчихсан байна.



Юу вэ? Нүд өвдөөд.

Ёооё өвдөөд, тэвчихгүй нь ээ.



Ажлаа үргэлжлүүлж чадахгүй нь.

Сэнпай уучилаарай, нүд өвдөөд ажлаа хийж чадахгүй нь.



Хараадахъя.




Юутай ч нүдээ угаа.



Хянагч! Түүний нүдэнд нунтаг үртэс орсон бололтой!

Юу? Нунтаг үртэс орчихсоон?



Энэ аюултай Одоо шууд нүдний эмч үрүү яв.

Түүнийг нүдний эмчид үзүүлсэн.



Эмхтгэл: Тохиолдол 3

1 Нунтаг үртэстэй бээлийгээр нүдний ойролцоо хүрч болохгүй



Ажлын дараа гараа угааж, хөлсөө арчихдаа бохир бээлийгээ тайлаарай.

2 Хэрэв таны нүдэнд нунтаг үртэс эсвэл төмрийн хэсгүүд орсон бол үрэлгүйгээр нэн даруй усаар угаах



Хэрэв угаасны дараа өвдөлт нь хэвээр байвал нүдний эмчид үзүүлээрэй. Хэрэв нүдний алим дээр зураас, үлдэгдэл байгаад эмчлэхгүй бол хараагаа алдаж магадгүй юм.

TIPS Гагнуурын гэрлийг хамгаалалтгүй нүдээр харж болохгүй!





Аюул гайхалтай ойрхон байгааг мэдрэв үү?



Тэмдэгтүүдийн тэнэг хэсэг нь хэн нэгэнтэй төстэй юм аа.

Айн? Ямар нэгэн юм хэлсэн үү?



Ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйн хувьд хувь хүн бүрийн ухамсар бөгөөд дүрмийг дагаж мөрдөх нь чухал юм.

Тэгээд...



Хөдөлмөрийн осол бол бусдын асуудал биш бидэнд ойрхон байдаг асуудал юм.

Дүрэм журмаа баримтлах нь "өөрийгөө", "гэр бүл", "амьдрал"-аа хамгаалж байна гэж санаж яваарай.



Хэрэв ямар нэг зүйл болвол Өдөр бүрийн ажил дээрх харилцаа холбоо бас чухал юм.



За.

Дүрэм журмаа баримтлаж өдөр бүр хичээцгээе.

Хамгаалах хэрэгсэл ГЭХ МЭТ

Биеийн хэмжээтэй таарахгүй эсвэл ямар нэгэн зүйл буруу байвал хариуцсан хүнээс асуугаарай.



Хамгаалалтын малгай


Толгойг цохилтоос хамгаална.



Эрүүний оосорыг тохируулж, хөдлөхгүй байхаар чангал. Хэрэв та нэг удаа ч байсан цохиулбал түүнийгээ солиорой.

Гагнуурын хамгаалалтын баг


Нүдийг хортой туяанаас хамгаалж, гагнуурын очис зэрэг нүүр үрүү цацрахаас хамгаална.



Ашиглалт хангасан зүйлийг хэрэглэх.

Сүүдэрлэх шил

Таны нүдийг хортой туяанаас хамгаалах



Нүүрэндээ тулгаж зүүх.

Хамгаалалтын шил

Үсэрч ирэх зүйл, тоос шороо, халуунаас нүдийг хамгаалах



Аюултай эсвэл хортой бодисын төрөлд тохирохыг хэрэглэнэ.

Амьсгалах хамгаалалтын хэрэгсэл

Уушгийг урьдчилан сэргийлэх

Тоосжилтын маск
Тоосоор амьсгалахаас сэргийлдэг.

Цахилгаан сэнсээр амьсгалын замыг хамгаалах төхөөрөмж (PAPR)

Тоосжилтын маскаас илүү өндөр хамгаалалттай бөгөөд цахилгаан сэнсээр шүүлтүүр материал (шүүлтүүр) -ээр цэвэршүүлсэн агаарыг нийлүүлдэг.




- Зөв маскаа сонгоорой
 - Улсын сорилтыг давсан бүтээгдэхүүн
 - Өөрийн нүүрэндээ наалдуулах
 - Ажлын дагуу сонгох
- Наалдацыг шалгах
- Ажлын өмнө үзэж шалгах
 - Хоолойн хавхлага, нүүрний гадаргуугийн бохирдол, хэв гажилт
 - Шүүлтүүр материалын бөглөрөл
 - Олс муудсан эсэх

Бээлий

Гарыг халуунаас, хурц зүйлээс хамгаалах

Гагнуур хийхэд зориулсан бээлий ашиглах. Урт ханцуйтай бээлийг хэрэглэх.



Аюулгүйн гутал


Хүнд зүйлээс хөлийг хамгаалах



Өөрт тохирсон хэмжээтэй гутал өмсөх.

Түрий

Гагнуурын очис зэргээс хамгаалах



Сулархааргүй байхаар өмсөх.


Хормогч

Бие махбодийг гагнуурын очис болон халахаас хамгаална



Аль болох урт зүүх.

Хувьсах нуман гагнуурын цахилгаан цочролоос урьдчилан сэргийлэх автомат төхөөрөмж



Цахилгаан цочролоос хамгаалах хэрэгсэл. Хувьсах нуман гагнуур (бүрээсийн нуман гагнуур) хийх үед тухайн газар хариуцсан хүн ашиглах зааварчилгааг өгсний дагуу ашиглах.

Зурагт номоор ойлгох

Гагнуурын аюулгүй байдал, эрүүл ахуй

2021 оны 3-р сарын хэвлэл

Хэвлүүлсэн: Эрүүл мэнд, Хөдөлмөр, Халамжийн яам

Төлөвлөлт: Mizuho Information & Research Institute, Inc.

Хамтын ажиллагаа: Гагнуурын ажилтай холбоотой
аюулгүй ажиллагааны боловсролын материал

Үйлдвэрлэл: Sideranch Inc.



Энэ материалтай холбоотой холбоо барих
Эрүүл мэнд, Хөдөлмөр, Халамжийн яамны
Хөдөлмөрийн стандартын товчооны
Аюулгүй ажиллагааны хэлтэс,
Аюулгүй байдал, эрүүл ахуйн газар